

2024 онд орон нутгийн төсвөөс 312,731.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, хуваарийн дагуу зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр зарцуулсан байна. Нийт төсвийн 75,9 хувийг цалин хөлс, 8,8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, бусад зарцуулалтыг хууль, тогтоол, тушаал шийдвэр, байгууллагын дотоод журмын холбогдох заалтуудад нийцүүлэн байгууллагын даргын тушаал шийдвэрээр зарцууллаа. Төсвийн нээлттэй ил тод байдлыг ханган Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ тайланг сар улирлаар нь гарган холбогдох газруудад хуулийн хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж, байгууллагын мэдээллийн самбарт төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, төсвийн төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсан харьцуулалтаар гарган байршуулж мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж хэвшсэн. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих ажлыг сайжруулж үндсэн хөрөнгө болон бараа материалын иж бүрэн бүртгэл тооллогыг хийн бүртгэлд байгаа тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтад байнгын хяналт тавьж хэвшсэн байна.